




ХАРИЛЦАН СУРАЛЦЪЯ

Малчин эмэгтэйчүүдийн манлайллыг бэхжүүлэх, туршлагыг түгээн дэлгэрүүлэх нь

СУРГАГЧ БАГШИЙН ХӨТӨЧ



Хөтөч

Энэхүү хөтөч нь “Малчин эмэгтэйчүүдийн манлайллыг бэхжүүлэх, туршлагыг түгээн дэлгэрүүлэх нь” төслийн хүрээнд хэрэгжүүлэх малчин эмэгтэйчүүдэд зориулсан “Харилцан суралцья” сургалт, нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэх сургагч багт нарт зориулсан.

Боловруулсан

П.Энхмаа Өгөөмөр мэдээллийн товчоо ТББ-ын захирал
А.Сумьяа Өгөөмөр мэдээллийн товчоо ТББ-ын УЗ-ийн гишүүн
М.Төгөлдөр Увс аймгийн Байгаль орчин. Аялал жуулчлалын газрын мэргэжилтэн

Зөвлөсөн

Б.Гомбосүрэн Хоршоо, бизнесийн зөвлөх

Бэлтгэсэн

С.Ууганцэцэг Creative hub дундын оффисын менежер

Хариуцлага

“Малчин эмэгтэйчүүдийн манлайллыг бэхжүүлэх, туршлагыг түгээн дэлгэрүүлэх нь” төслийг Монголын эмэгтэйчүүдийн сангийн санхүүгийн дэмжлэгээр хэрэгжүүлж байна. Хөтөч нь санхүүжүүлэгч байгууллагын байр суурийг илтгэхгүй бөгөөд агуулгад МОНЭС хариуцлага хүлээхгүй болно.

Гарчиг

Эхлэл _____	4
Тайлбар _____	5
Зохион байгуулалт _____	6
Зөвлөмж _____	6
“Харилцан суралцъя” сургалтын удирдамж _____	7
Сургалт, нөлөөллийн ажлын хөтөлбөр _____	9
Уур амьсгалын өөрчлөлт- дасан зохицох боломж _____	10
Цэцэг бүтээх дасгал _____	10
Агуулга: 30, 20, 10 нэхэн санацгаая! 20, 30, 50 анзаарч ойлгон, хичээе! _____	11
Үнэлгээний хуудас _____	12
Тэмдэглэл _____	13-16

ЭХЛЭЛ

Өгөөмөр мэдээллийн товчоо ТББ нь Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, даван туулах агуулгаар олон нийтийн ухамсар, ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор “Хатан зоригийн үлгэр” эвентийн 6 дугаарыг байгаль орчны сэдвээр зохион байгуулсан байна. “Хатан зоригийн үлгэр” бол амьдралд ирсэн боломжийг хүлээн авч, айдас сорилтоо давж бүтээсэн хүчирхэг түүхүүд бөгөөд Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицож даван туулж буй хувь хүн, байгууллагуудын эерэг өөрчлөлтийн түүхийг 6 сэдвийн хүрээнд 30 оролцогчийн түүхийг хуваалцаад байна.

Бид энэхүү туршлагадаа тулгуурлан байгальд ээлтэй, бүтээмж өндөр, тэсэж, даван туулж буй туршлагауудыг харилцан түгээх, уг асуудалд малчин эмэгтэйчүүдийн манлайллыг нэмэгдүүлэх зорилгоор “Өгөөмөр мэдээллийн товчоо” ТББ, “Крийтив хаб” дундын оффисоос **Малчин эмэгтэйчүүдийн манлайллыг бэхжүүлэх, туршлагыг түгээн дэлгэрүүлэх нь төслийг хэрэгжүүлж байна.**

Дээрх төслийн хүрээнд “Харилцан суралцъя” сургалт нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэх бөгөөд сургагч багшид зориулсан хөтчийг ашиглан сургалт, нөлөөллийн ажлаа хэрэгжүүлнэ.

Сургагч багшид зориулсан сургалтын хөтөч үндсэн гурван модультай. Нэгдүгээрт Уур амьсгалын талаарх суурь ойлголт ба дасан зохицох, даван туулах тухайд, хоёрдугаарт Эмэгтэйчүүдийн манлайлал, туршлагыг түгээн дэлгэрүүлэх, хамтран ажиллах, гуравдугаарт хэлэлцүүлэг, оролцогчдын түүхийг сонсох гэсэн агуулгыг багтаалаа. Агуулгууд нь сургалтыг оролцооны аргаар явуулахаар боловсруулсан юм.

Өгөөмөр мэдээллийн товчоо ТББ

Тайлбарууд

Хөтчийг сургалтаа амжилттай зохион байгуулах зорилгоор ашиглана. Сургалт нь үндсэн гурван агуулгаас бүрдэж байна. Сургалтаа эхлэхдээ сургалтын зорилтууд, хөтөлбөрөө танилцуулж, оролцогчдынхоо хүлээлт, хэрэгцээг тодруулж, төгсгөлд нь тухайн асуудлаарх мэдлэг хэрхэн нэмэгдсэнийг үнэлнэ.

Түлхүүр үгс: Тухайн хэсэгт оролцогчдын заавал ойлгож мэдсэн байх үг, өгүүлбэрүүдийг оруулсан

Дасгалууд: Дасгалууд нь хөтчийн хамгийн чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Дасгалууд нь оролцооны аргаар хийхээр боловсруулагдсан. Оролцогчдыгоо хэн нэгнийг орхигдуулахгүй, тэгш оролцоог хангаж, сонирхолтой байдлаар явуулахад анхаараарай.

Сургалтад ашиглах хэрэглэгдэхүүн: Дасгал бүрд шаардлагатай зүйлсийн жагсаалтыг гаргадаг тул сургагч багш бэлтгэлтэй ирнэ.

Сургалтаа төлөвлөх. Сургалтын зорилтод бүлэг нь малчин эмэгтэйчүүд байна.

Сэдэв	Хэрэгтэй зүйлс	Тайлбар
Бэлтгэх материал	Самбарын болон тэмдэглэлийн цаас, маркер Оролцогчдод зориулсан бичиг хэргийн хэрэгсэл	Тухайн сэдвийг заахад ашиглах хэрэглэгдэхүүн
Зорилго	Сургалтын зорилгоо тодорхойлох: Уур амьсгалын өөрчлөлтийн тухай ойлголтыг дээшлүүлэх... гэх мэт	Оролцогчдод ямар ойлголт мэдлэгтэй болохыг төлөвлөх
Бэлтгэл	Танилцуулга Бүлгээр ажиллах (хэрхэн яаж)	Сургалт эхлэхийн өмнө бэлтгэсэн байна
Багшийн үүрэг	Оролцогчдын ойлголт мэдлэгийг нэгтгэх Хэн нэгнийг орхигдуулахгүй, тэгш оролцоог хангах Нэгтгэн дүгнэлт хийх, тухайн асуудлаар нэмэлт санал дүгнэлтүүдийг сануулах	Сургалтын тухайн хэсгийг явуулах дараалал
Дараагийн хэсэгт шилжих	Сургалт нь нэг хэсгээс дараагийн хэсэг рүү шилжиж байна гэдгийг оролцогчдодоо заавал танилцуулах	Тухайн хэсэг дараагийн сэдэвтэй хэрхэн холбогдож буйн харуулах

Зохион байгуулалт

Нийт 8 цагийн сургалт байна:

1. Үндсэн сургалт: Уур амьсгалын өөрчлөлт-Дасан зохицох, даван туулах боломж (240 мин)
2. “Өрхийн орлого ба эмэгтэйчүүд” түүх хуваалцах, эргэцүүлэн бодох (90 мин)
3. Хэлэлцүүлэг: Түгээн дэлгэрүүлэх туршлага, санаачилгаа хэлэлцэн тогтох (60 мин)
4. Сургалтаа үнэлүүлэх, ярилцлага авах (40 мин)
5. “Хатан зоригийн үлгэр” туршлага хуваалцах эвентийн мэдээлэл өгөх

Зөвлөмж

- Урам зоригтой, өөдрөг, эерэг байгаарай! Оролцогчдод тухайн сургалтыг сэтгэл хангалуун төгсгөхөд таны урам зориг тэдэнд хэрэгтэй.

- Хөдөлгөөнтэй байлга. Удаан хугацаанд хөдөлгөөнгүй байх нь оролцогчдын идэвх сонирхлыг бууруулдаг. Хөдөлгөөнтэй байх нь оролцогчдыг татан оролцуулж, анхаарлыг нь төвлөрүүлж, хүн бүр таныг сонсоход тусалдаг.

- Хэлэлцэх асуудлаа уян хатан байлгаарай. Оролцогчид тухайн сургалтын агуулгыг ойлгох нь чухал бөгөөд хэрэв та нэг асуудал дээр удаан төвлөрөх, тал бүрээс авч үзэхийг чухалд үздэг бол танд нэмэлт цаг хэрэгтэй. Цагаа нэмж төлөвлөөрэй.

- Тухайн сургалтын дараа сургалтыг зохион байгуулж байгаа багтай уулзан, ярилцаж дүгнэлт хийгээрэй. Энэ нь сургалтыг амжилттай явуулж, үр дүнд хүрэхэд чухал ач холбогдолтой.

- Сургалтын агуулгаа зааж дууссаны дараа шинээр юу сурав, ямар асуудал ойлгомжтой, ямар нь ойлгомж муутай байсан эсэхийг заавал асуугаарай. Сургалтыг цаашид үр дүнтэй явуулахад та бүхэнд хэрэгтэй.

Амжилт хүсье!

Батлав.

“Харилцан суралцъя” сургалт, нөлөөллийн ажлын удирдамж

by creative hub coworking space

ТАНИЛЦУУЛГА

Увс аймаг 22,3 орчим мянган өрхтэй. Үүний 9,8 мянга нь малчин өрх. Увс аймгийн Цагаанхайрхан сумаас бусад 18 суманд бэлчээрийн даац 15-20 хувиар хэтэрчээ. Зудад малаа алдах, цаг бусын байгалийн гэнэтийн гамшигт мал нь хорогдох зэргээр уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөнд тэд хэдийн өртөж эхэлсэн. /2008, 2009 оны зуд, 2015 оны 4-р сард орсон их цас, 2022 оны зуны ган гэх мэт/

Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн бий болж буй цаг агаарын гэнэтийн гамшигт үзэгдэл, бэлчээрийн ургамлын зүйлийн хомсдол зэрэг нь малчдын амьжиргаанд шууд нөлөөлж буйг малчдад таниулан ойлгуулж, мал аж ахуйгаа уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох хэлбэрээр эрхлэхэд туслах нь мал аж ахуйн давамгайлсан аж ахуйтай орон нутгийн хувьд нэн чухал юм.

Мал аж ахуйгаа уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох хэлбэрээр авч үлдэхийн тулд фермерийн аж ахуй эрхлэх, нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгаалал, мал аж ахуйд байгаль ээлтэй, бүтээмж өндөр менежмент хэрэгжүүлэхийг мэргэжлийн байгууллагууд зөвлөдөг. Иймээс байгальд ээлтэй, бүтээмж өндөр, тэсэж, даван туулж буй туршлагуудыг харилцан түгээх, уг асуудалд малчин эмэгтэйчүүдийн манлайллыг нэмэгдүүлэх зорилгоор “Өгөөмөр мэдээллийн товчоо” ТББ, “Крийтив хаб” дундын оффисоос **Малчин эмэгтэйчүүдийн манлайллыг бэхжүүлэх, туршлагыг түгээн дэлгэрүүлэх нь төслийг хэрэгжүүлж байна.**

Дээрх төслийг Монголын эмэгтэйчүүдийн сангаас хэрэгжүүлж буй **Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг бууруулах үйл ажиллагааг манлайлагч эмэгтэйчүүд төслийн санхүүгийн дэмжлэг, Увс аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжил, арга зүйн хамтын ажиллагаагаар хэрэгжүүлж байна. Малчин эмэгтэйчүүдийн манлайллыг бэхжүүлэх, туршлагыг түгээн дэлгэрүүлэх нь төслийн хүрээнд:**

1. “Харилцан суралцъя” сургалт, нөлөөллийн ажил

2. “Хатан зоригийн үлгэр” манлайлагч эмэгтэйчүүдийн туршлага хуваалцах эвент гэсэн дэд ажлуудыг хэрэгжүүлнэ.

Төслийн хүрээнд хэрэгжүүлэх ажлууд нь Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицоход эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэх бөгөөд эмэгтэйчүүд, эмэгтэйчүүддээ нөлөөлөхөөс гадна эмэгтэйчүүд байгаль хамгаалах нөхөрлөлийнхөө жилийн ажлын төлөвлөгөөнд өөрсдийн манлайллыг бэхжүүлж, сайн туршлагуудаа харилцан судалж, нутагшуулах юм.

ЗОРИЛГО:

Увс аймгийн байгаль хамгаалах малчдын нөхөрлөлийн гишүүн эмэгтэйчүүдийн мал аж ахуйгаа байгаль ээлтэй эрхэлж буй туршлага, бизнес, үйлдвэрлэлийн салбарт ажиллаж буй эмэгтэйчүүдийн туршлага, мэдлэгийг хуваалцаж, хоорондын хамтын ажиллагааг эхлүүлэх, Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицож, даван туулах талаарх мэдээлэл, нөлөөллийн ажил зохион байгуулах.

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө хамгийн их мэдрэгдэж буй сумдын нэг. Газарзүйн хувьд говирхог, Увс аймгийн Завхан сумын төвд зохион байгуулах юм.

АГУУЛГА: “Харилцан суралцъя” сургалт, нөлөөллийн ажил нь хамтдаа асуудлаа танин мэдэж, тодорхойлж, харилцан туршлагаа хуваалцах гэсэн зарчим баримтална. Агуулгын дараалал:

1. Уур амьсгалын өөрчлөлт- Дасан зохицох боломж
2. “Өрхийн орлого ба эмэгтэйчүүд” туршлагын сүлэлдээн
3. Collective care

ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН: “Харилцан суралцъя” сургалт, нөлөөллийн ажилд нийт 80 эмэгтэй оролцож, харилцан мэдээлэл, туршлагаа хуваалцсан байна. Үүний үр дүнд: Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулахад хүн бүрийн оролцоог идэвхжүүлж аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх нэг санаачилга, байгаль хамгаалах нөхөрлөлийн гишүүн эмэгтэйчүүдээр дамжуулан байгаль ээлтэй аж ахуйн эрхлэх нэг туршлагыг түгээн дэлгэрүүлнэ. Оролцогч эмэгтэйчүүдийн сайн түүх, туршлагуудыг сурталчлах, таниулах 10 минутын нэвтрүүлэг бэлтгэж, түгээх, төслийн хүрээнд хэрэгжүүлэх “Хатан зоригийн үлгэр” туршлага хуваалцах эвентэд оролцох оролцогчийг тодорхойлно.

“Харилцан суралцъя” сургалт, нөлөөллийн ажлын хөтөлбөр

Үйл ажиллагаа	Чиглүүлэх
Бүртгэл, оролцогчдын угтах, бэлтгэл хангах, хөнгөн ундаар үйлчлэх	Зохион байгуулагч Бүртгэлийн хуудас ашиглан бүртгэнэ.
Сургалтын нээлт	Зохион байгуулагч болон хамтрагч байгууллагын төлөөлөл
Танилцах: Оролцогчид 8 бүлэг болон хуваагдаж, багийн танилцуулга хийнэ.	П.Энхмаа Сургалтын гарын авлага ашиглан чиглүүлнэ.
30, 20, 10 нэхэн санацгаая! 20, 30, 50 анзаарч ойлгон, хичээе!	М.Төгөлдөр П.Энхмаа
Уур амьсгалын өөрчлөлтийн сорилт, даван туулах манлайлал, эерэг өөрчлөлт	М.Төгөлдөр
Нэгдүгээр хэсгийн дүгнэх	П.Энхмаа
Өдрийн хоол	
Хоёр хэсгээ танилцуулж, туршлага хуваалцах зочдоо танилцуулна	П.Энхмаа Өгөөмөр мэдээллийн товчоо ТББ-ын захирал
Хэлэлцүүлэг: Өрхийн орлого ба эмэгтэйчүүдийн манлайлал	Шинэ санаачилга, хэрэгжүүлэх төлөвлөгөө танилцуулна.
Үр дүнгээ танилцуулах малчдын дунд өрнүүлэх санаачилгын төлөвлөгөө	Аймгийн хэмжээнд малчин эмэгтэйчүүд өрнүүлж, хэрэгжүүлэх ажлын санаачилга
цайны завсарлага	Өгөөмөр мэдээллийн товчоо ТББ
Тусгай хөтөлбөр	Collective care

Цэцэг бүтээх дасгал ажил:

Зорилго: Оролцогчдын туршлагыг илрүүлэх, тэдний эрэлхийлэх, эргэцүүлэх, илэрхийлэх чадварт тулгуурлан сургалтын үндсэн агуулгад хөглөх.

Үр дүн:

- Оролцогчдын бие биеэ туршлага, хүсэл эрмэлзлээр нь таньдаг болно.
- Малчин эмэгтэйчүүд өөрсдийн нийтлэг асуудлуудаа өөрсдөө тодорхойлж, харилцан бие биеэсээ суралцах эхлэлийг тавина.
- Үндсэн агуулгад төвлөрч, өөрсдийн туршлагаас хуваалцаж, мэдлэгээ бататгана

Дараалал	Хэрэглэгдэхүүн	Хугацаа
Оролцогчид өөрсдийн хамгийн сайн хийж чаддаг зүйлсээ хэлнэ.	Нэг хүн 1 хүртэл минут ярина. Тойрог 10 минутаас хэтрэхгүй.	10 минут
Оролцогчид өгөгдсөн асуултын дагуу багаар ажиллаж цэцэг бүтээнэ.	1. Бидний хамгийн сайн хийж чаддаг зүйлс? Туршлага 2. Уламжлал, соёл, заншил? 3. Байгалийн нөөц? 4. Нутгийн брэнд хоол? 5. Нийтлэг бэрхшээл, сорилт? 6. Ан, амьтан, байгалийн үзэсгэлэн? 7. Амьжиргааны гол орлого? 8. Бидэнд дутагдах буй, хэрэгтэй зүйлс?	12 минут
Самбарт гаргаж цэцэг бүтээж, наана.	Цавуу, самбарын цаас	5 минут
Дүгнэлт: Чиглүүлэгч дүгнэнэ.	оролцогчдыг хүсэл, зоригийг нэгтгэн, дүгнэж дараагийн агуулгатай холбоно.	5 минут

Агуулга: 30, 20, 10 нэхэн санацгаая! 20, 30, 50 анзаарч ойлгон, хичээе!

Зорилго: Хүрээлэн буй орчин, уур амьсгал хэрхэн өөрчлөгдөж буйг, өөрчлөгдөхийг оролцогчдын оролцоотойгоор тодорхойлж, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх цэгцтэй ойлголт өгөх.

Дараалал	Хэрэглэгдэхүүн	Хугацаа
Асуулт -1: Оролцогчдоос 30, 20, 10 жилийн өмнө нутаг ус, хүрээлэн буй орчны зүйлс хэрхэн хувьсаж буйг асууна.	Оролцогчдоор булаг шанд, ургамал, амьтан гэх зэргээр багассан, байхгүй болсон зүйлсийг тоочин хэлүүлнэ.	3 минут
Сургагч багш Уур амьсгалын өөрчлөлтийн талаар үндсэн ойлголтоо өгнө.	Урьдчилан бэлтгэсэн РРТ үзүүлэн чиглүүлнэ.	5 минут
20, 30, 50 биднийг юу хүлээж байна вэ?	Урьдчилан бэлтгэсэн РРТ үзүүлэн чиглүүлнэ.	5 минут
Асуулт -2: Та аз, зээ нараа ямар орчинд амьдраасай гэж хүсэж байна вэ?	Оролцогчдыг саналыг, сэтгэгдлүүдийг хүлээнэ авна.	2 минут
Дүгнэлт: Чиглүүлэгч дүгнэнэ.	оролцогчдыг хүсэл, зоригийг нэгтгэн, дүгнэж дараагийн агуулгатай холбоно.	5 минут

Энэ хэсэгт:

Ойлголт:

Уур амьсгалын өөрчлөлт
Түүнийг бууруулах, саармагжуулах
Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох
Малчдын хувь нэмэр
Нөлөөлөх, дэмжих, оролцох арга

ТҮЛХҮҮР ҮГС:

- Цаг агаар ба Уур амьсгалын өөрчлөлт
- Хүний нөлөө
- Дасан зохицох
- Даван туулах

Үнэлгээний хуудас

“Харилцан суралцъя” сургалт, нөлөөллийн ажил үнэлгээний хуудас

Он.сар.өдөр

хаана:.....

Сургагч багш/Агуулууд	Үнэлгээ				
	Маш сайн-5	сайн-4	дунд-3	онцдын чухал биш-2	муу-1
Сургалтуудыг үнэлнэ үү.					
30, 20, 10 нэхэн санацгаая! 20, 30, 50 анзаарч ойлгон, хичээе!					
Уур амьсгалын өөрчлөлтийн сорилт, даван туулах манлайлал, эерэг өөрчлөлт					
Нэгдүгээр хэсгийн дүгнэх					
Сургагч багш, чиглүүлэг нарыг үнэлнэ үү.					
Чиглүүлэгч П.Энхмаа					
М.Төгөлдөр					
М.Энхмаа					
Зочин илтгэгч					
Зочин илтгэгч-1					
Зочин илтгэгч-2					
Зочин илтгэгч-3					
Зохион байгуулалт					
Хөнгөн унд					
хоол					
Заал					
Сургалтын агуулга					
Танд хамгийн их таалагдсан агуулга аль нь вэ?					
Та амьдралдаа хэрэгжүүлэх ямар санаа олж авсан бэ?					
Бидэнтэй хуваалцах таны туршлага?					
Цаашид сайжруулах зүйлс					

